

ӨГИЙ НУУРЫН ЭРЭГ ДАГУУХ ОРЧМЫН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН

(Архангай аймаг, Өгийнуур сум)

2026 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр

Нэг. Зорилго

Архангай аймгийн Өгийнуур суманд зохион байгуулагдсан Өгий нуурын тахилгын арга хэмжээний дараа үүссэн хог хаягдлыг цэвэрлэх, нуурын экосистемийг хамгаалах, эрэг орчмын цэвэр, аюулгүй орчныг бүрдүүлэх, мөн байгууллагын ажилтан, албан хаагчдын байгаль орчныг хамгаалах чиглэлээрх идэвх санаачилга, хамтын оролцоог өрнүүлэх зорилгоор Монгол Улсын Далайн захиргааны даргын 2026 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/136 дугаар тушаалын дагуу томилолтоор ажиллав.

Хоёр. Хугацаа, оролцогчид болон хамтран ажилласан байгууллагууд

- Ажлын хугацаа: 2026 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс 09 дүгээр сарын 06-ны өдрүүдэд.
- Байршил: Архангай аймаг, Өгийнуур сум, Өгий нуурын эрэг орчим.

Хамтран оролцсон байгууллагууд:

- Монгол Улсын Далайн захиргаа (Ажилтан, албан хаагчид)
- Архангай аймгийн Өгийнуур сумын Засаг даргын Тамгын газар
- Орхон-Чулуут голын сав газрын захиргаа
- Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүд

Гурав. Гүйцэтгэсэн ажил

Өгий нуурын эрэг орчмын цэвэрлэгээний ажлыг дараах хуваарийн дагуу зохион байгуулан гүйцэтгэлээ:

- 2026.09.04 (1 дэх өдөр): Ажилтан, албан хаагчид Улаанбаатар хотоос Архангай аймгийн Өгийнуур сум руу хөдөлж, цэвэрлэгээний ажлын зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангасан.
- 2026.09.05 (2 дахь өдөр): Өгий нуурын эрэг орчмын хог хаягдлыг цуглуулах, ангилах, зориулалтын уут, шуудайнд хийн тогтоосон цэгт төвлөрүүлэх цэвэрлэгээний үндсэн ажлыг хамтран оролцогч байгууллагуудын хамт гүйцэтгэв.
- 2026.09.06 (3 дахь өдөр): Цуглуулсан үлдэгдэл хог хаягдлыг хөлсөөр ажиллуулсан тээврийн хэрэгслээр ачин сумын төвлөрсөн хогийн цэгт зааврын дагуу аюулгүй хүргэж төвлөрүүлэх, цэвэрлэсэн талбайг эцэслэн шалгах, тайлан фото баримт бүрдүүлэх ажлыг хийж, Улаанбаатар хот руу буцах ажлыг зохион байгуулав.

Дөрөв. Дүгнэлт

- Архангай аймгийн Өгийнуур сумын Засаг даргын Тамгын газар болон Орхон-Чулуут голын сав газрын захиргаатай хамтран Өгий нуурын эрэг дагуух хог хаягдлыг иж бүрэн цэвэрлэж, түрээсийн тээврийн хэрэгслээр сумын төвлөрсөн хогийн цэгт зохион байгуулалттайгаар ачин хүргэж төвлөрүүлснээр нуурын экосистемийг хамгаалах, иргэд болон амрагчдад цэвэр, аюулгүй орчин бүрдүүлэх зорилго бүрэн биелэв.

- Төрийн байгууллагууд болон орон нутгийн иргэд, аялал жуулчлал эрхлэгчдийн хамтын ажиллагаа, оролцоо идэвхтэй байж, цэвэрлэгээний ажил болон хог хаягдлын нэгдсэн тээвэрлэлтийг батлагдсан удирдамж, зардлын төсвийн дагуу амжилттай хийж гүйцэтгэлээ.

Тав. Санал, зөвлөмж

- Аялал жуулчлалын ачаалал ихсэх үе болон тахилгын арга хэмжээний дараах цэвэрлэгээний ажлыг жил бүрийн 9 дүгээр сард уламжлал болгон орон нутгийн байгууллагуудтай хамтран тогтмол зохион байгуулж хэвших.
- Нуурын эрэг дагуу аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийн хог хаягдлын менежментийг сайжруулж, урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх.

Зургаа. Фото баримтжуулалт (Арга хэмжээний үеэр авсан зургууд)



ТАНИЛЦСАН:

ДАРГА

М.ӨЛЗИЙ

ХЯНАСАН:

ЗУХ-ИЙН ДАРГА

Т.МӨНХБАЯР

ТАЙЛАН БИЧСЭН:

ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

С.Мөнхбаяр

С.МӨНХБАЯР